



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/106/НА- СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сарын 20-ний өдөр</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a> Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: <a href="mailto:dojmaab@audit.gov.mn">dojmaab@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр: “Номгон Аудит” ХХК Захирал: Г.Саранчимэг Аудитор: О.Мандах Утас: 89010203 Цахим хаяг: <a href="mailto:audit.nomgon@gmail.com">audit.nomgon@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	3
<b>Аудитын гол асуудал</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	14
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	14
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	14
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>	14
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	15
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/46

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 12 арга хэмжээний зардалд 1,029,030.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 960,397.6 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст харилцах дансанд 67,887.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

5020186

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 81,6 хувиар үнэлсэн байна. Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй,

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>116,317,953.08</u></b>	<b><u>172,251,908.64</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	20,431,362.36	67,887,965.62
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	20,431,362.36	67,887,965.62
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	20,431,362.36	67,887,965.62
31211	Төрийн сангийн харилцах	20,431,362.36	67,887,965.62
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	95,324.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	95,324.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	69,767,028.72	78,149,057.02
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	122,000.00	122,000.00
35110	Тусгай зориулалттай материал	122,000.00	122,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	69,645,028.72	78,027,057.02
35410	Бичиг хэргийн материал	3,467,057.72	6,544,571.02
35420	Аж ахуйн материал	5,562,200.00	2,693,000.00
35460	Хүнсний материал	450,000.00	1,040,300.00
35470	Бусад хангамжийн материал	60,165,771.00	67,749,186.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	26,119,562.00	26,119,562.00
36600	Бусад нөөц	26,119,562.00	26,119,562.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>728,321,050.05</u></b>	<b><u>1,912,512,097.51</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	728,321,050.05	1,912,512,097.51
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	701,545,050.05	1,885,736,097.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	616,742,220.00	1,747,053,799.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-70,723,425.86	-89,000,333.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	208,788,685.60	291,260,779.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-128,186,488.51	-154,608,063.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,381,211.18	137,781,211.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,289,000.00	7,289,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,666,758.15	-6,282,000.00
39217	Ном	14,877,955.20	14,877,955.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	26,776,000.00	26,776,000.00
39301	Програм хангамж	675,000.00	675,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-675,000.00	-675,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,776,000.00	26,776,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>844,639,003.13</u></b>	<b><u>2,084,764,006.15</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>844,639,003.13</u></b>	<b><u>2,084,764,006.15</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	844,639,003.13	2,084,764,006.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	417,388,192.00	417,388,192.00
51101	Өмч: - төрийн	417,388,192.00	417,388,192.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-26,526,663.87	1,213,598,339.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-26,526,663.87	-26,526,663.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,240,125,003.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	453,777,475.00	453,777,475.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>844,639,003.13</u></b>	<b><u>2,084,764,006.15</u></b>

### 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /ТӨГРӨГӨӨР/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>872919957.72</b>	<b>2240499400.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,007,057.72</b>	<b>1,233,322,300.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	25,007,057.72	1,233,322,300.90

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,007,057.72	1,007,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,281,800.00	902,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	105,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,675,257.72	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>847,912,900.00</b>	<b>1,007,177,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>716,602,600.00</b>	<b>915,914,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	716,602,600.00	915,914,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>500,000.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>130,810,300.00</b>	<b>91,262,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,810,300.00	91,262,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>875,365,002.29</b>	<b>1,000,374,397.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>875,365,002.29</b>	<b>1,000,374,397.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>834,389,581.29</b>	<b>958,707,895.76</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>532,167,159.64</b>	<b>640,491,140.26</b>
210101	Үндсэн цалин	360,069,444.64	431,914,134.58
210102	Нэмэгдэл	129,741,579.00	179,659,311.68
210104	Урамшуулал	17,640,314.00	28,917,694.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,715,822.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>65,480,000.00</b>	<b>80,218,099.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	65,480,000.00	80,218,099.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>87,235,098.00</b>	<b>88,932,197.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,629,428.00	4,545,225.48
210302	Түлш, халаалт	80,805,670.00	82,100,790.40
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	2,286,182.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,798,530.00</b>	<b>11,887,880.00</b>
210401	Бичиг хэрэг	370,880.00	1,735,480.00
210402	Тээвэр, шатахуун	2,580,150.00	2,821,400.00
210404	Ном, хэвлэл	287,800.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,559,700.00	7,331,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>53,057,100.00</b>	<b>53,798,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,200.00	00.00
210502	Хоол, хүнс	51,036,900.00	53,798,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,881,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,500,000.00</b>	<b>6,750,000.00</b>
210604	Урсгал засвар	9,500,000.00	6,750,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,969,050.00</b>	<b>4,909,033.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,932,700.00	902,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,036,350.00	4,006,333.48
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>72,182,643.65</b>	<b>71,721,545.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,051,225.00	11,711,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,196,400.00	7,017,620.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,935,018.65	52,992,625.14

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	40,975,421.00	41,666,502.12
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	35,876,200.00	41,336,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,876,200.00	41,336,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,049,221.00	330,502.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,049,221.00	330,502.12
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	50,000.00	00.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	50,000.00	00.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-2,445,044.57</b>	<b>1,240,125,003.02</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-2,445,044.57</b>	<b>1,240,125,003.02</b>

**2.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>849,244,700.00</b>	<b>1,008,184,800.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,331,800.00</b>	<b>1,007,700.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,331,800.00	1,007,700.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,331,800.00	1,007,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,281,800.00	902,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.00	105,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>847,912,900.00</b>	<b>1,007,177,100.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	716,602,600.00	915,914,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	716,602,600.00	915,914,400.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	130,810,300.00	91,262,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,810,300.00	91,262,700.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>816,841,337.64</b>	<b>942,853,196.74</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>816,841,337.64</b>	<b>942,853,196.74</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>773,039,116.64</b>	<b>900,416,394.62</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	532,167,159.64	640,491,140.26
210101	Үндсэн цалин	360,069,444.64	429,605,883.58
210102	Нэмэгдэл	129,741,579.00	184,026,466.68
210104	Урамшуулал	17,640,314.00	26,858,790.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,715,822.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	65,480,000.00	80,313,423.00
210201	Тэтгэврийн даатгал	44,560,000.00	54,239,023.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,230,000.00	6,470,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,184,100.00	5,116,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,045,900.00	1,323,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,460,000.00	13,163,700.00

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	88,435,257.00	88,932,197.88
210301	Гэрэл, цахилгаан	4,629,428.00	4,671,407.48
210302	Түлш, халаалт	82,005,829.00	82,100,790.40
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	2,160,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48,480,100.00	53,618,000.00
210502	Хоол, хүнс	48,480,100.00	53,618,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,500,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	9,500,000.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,318,150.00	5,866,033.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,281,800.00	902,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,036,350.00	4,963,333.48
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,658,450.00	29,195,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,172,050.00	21,749,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,486,400.00	7,446,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,802,221.00</b>	<b>42,627,746.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	38,703,000.00	42,297,244.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,703,000.00	42,106,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,049,221.00	330,502.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,049,221.00	330,502.12
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	50,000.00	00.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	50,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>32,403,362.36</b>	<b>65,331,603.26</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,972,000.00</b>	<b>17,875,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,972,000.00</b>	<b>17,875,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	11,972,000.00	17,875,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,972,000.00	17,875,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-11,972,000.00</b>	<b>-17,875,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	20,431,362.36	47,456,603.26
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	20,431,362.36
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	20,431,362.36	67,887,965.62

**2.4 АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	417,388,192.00	453,777,475.00	-26,526,663.87	844,639,003.13

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	417,388,192.00	453,777,475.00	-26,526,663.87	844,639,003.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	417,388,192.00	453,777,475.00	-26,526,663.87	844,639,003.13
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,240,125,003.02	1,240,125,003.02
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	417,388,192.00	453,777,475.00	1,213,598,339.15	2,084,764,006.15

2.5 АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,029,030,100.0	960,397,694.7	68,632,405.3	93.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,029,030,100.0	960,397,694.7	68,632,405.3	93.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	981,263,400.0	918,291,394.7	62,972,005.3	93.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	695,559,200.0	640,491,140.3	55,068,059.7	92.1
210101	Үндсэн цалин	477,284,300.00	429,605,883.6	47,678,416.4	90.0
210102	Нэмэгдэл	190,059,100.00	184,026,466.7	6,032,633.3	96.8
210104	Урамшуулал	28,215,800.00	26,858,790.0	1,357,010.0	95.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,945,100.0	80,313,423.0	6,631,677.0	92.4
210201	Тэтгэврийн даатгал	59,122,700.00	54,239,023.0	4,883,677.0	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,955,600.00	6,470,900.0	484,700.0	93.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,564,400.00	5,116,300.0	448,100.0	91.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,391,200.00	1,323,500.0	67,700.0	95.1
210205	Эрүүл мэндийн даатгал	13,911,200.00	13,163,700.0	747,500.0	94.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,262,700.0	88,932,198.0	330,502.0	99.6
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.0	4,671,407.5	328,592.5	93.4
210302	Түлш, халаалт	82,102,700.0	82,100,790.5	1,909.5	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,160,000.0	2,160,000.0	00.0	100.0
2105	Нормативт зардал	53,810,300.0	53,618,000.0	192,300.0	99.6
210502	Хоол, хүнс	53,810,300.0	53,618,000.0	192,300.0	99.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,335,000.0	5,866,033.5	468,966.5	92.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,370,900.0	902,700.0	468,200.0	65.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,964,100.0	4,963,333.5	766.5	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,351,100.0	47,070,600.0	280,500.0	99.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,905,000.0	39,624,500.0	280,500.0	99.3

**Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,446,100.0	7,446,100.0	00.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.0	42,106,300.0	-42,106,300.0	0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	47,766,700.00	42,106,300.0	5,660,400.0	88.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,766,700.00	42,106,300.0	5,660,400.0	88.1
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,029,030,100.0	1,008,184,800.1	18,162,099.9	98.2
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	915,914,400.0	915,914,400.0	0	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	915,914,400.0	915,914,400.0	0	100
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	91,262,700.0	91,262,700.1	-00.1	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	91,262,700.0	90,932,197.9	330,502.1	99.6
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	21,853,000.0	1,007,700.0	20,845,300.0	04.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,370,900.0	902,700.0	468,200.0	65.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.0	105,000.0	00.0	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	20,377,100.00	00.0	20,377,100.0	00.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.0	20,431,362.4	-20,431,362.4	0
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.0	67,887,965.6	-67,887,965.6	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	39	39	00	100
620001	Удирдах ажилтан	01	01	00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	26	26	00	100
620003	Үйлчлэх ажилтан	09	09	00	100
620004	Гэрээт ажилтан	06	06	00	100
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	291	297	-6	102
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	291	297	-6	102
630001	Төрийн өмчит ЕБС	291	297	-6	102

### **3 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургууль сургууль нь “Сурах хүсэл тэмүүлэлтэй,эрүүл зөв дадал хэвшилтэй суралцагчдтай болох” гэсэн зорилтын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, биелэлтийг 81,6 хувьтай тайлагнасныг дээд шатны байгууллагаас 80.5 хувьтай дүгнэсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаалаар сургуулийн зөвлөл, хүүхэд хөгжлийн алба, сургалтын алба, захиргаа аж ахуй гэсэн бүтэц зохион байгуулалттай 39 орон тоотой 296 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Д. Болор-эрдэнэ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Ганболд нар зурсан байна.



### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2 өдрийн 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”, 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 131 дүгээр тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12 өдрийн А/170 дугаар тушаал “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал” мөн 2022 оны 10 дугаар сарын 26 өдрийн А/430 “Багшийн ажлыг үнэлэх журам” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж ажиллаж байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын түвшинд гүйцэтгэл үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл чанар үр дүнг улсын хэмжээнд нэгдсэн шалгуураар хөндлөнгөөс үнэлж гүйцэтгэлийн урамшуулал олгох, багийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, сургалт үйл ажиллагаанд хамруулах зэрэг олон үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс өгсөн чиглэл дагуу бэлтгэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь

холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.240.1 мянган төгрөгөөр буюу 59.4 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт А	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	20,431.4	67,888.0	47,456.6
Авлага	0.0	95.3	95.3
Бараа материал	95,886.6	104,268.6	8,382.0
Үндсэн хөрөнгө	988,530.1	2,225,713.7	1,237,183.7
хуримтлагдсан элэгдэл	-260,209.0	-313,201.6	-52,992.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>844,639.0</b>	<b>2,084,764.0</b>	<b>1,240,125.0</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	844,639.0	2,084,764.0	1,240,125.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>844,639.0</b>	<b>2,084,764.0</b>	<b>1,240,125.0</b>

Эх сурвалж: Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд төрийн сангийн санхүүжилтийн дансаар санхүүжилтийн орлого 1,007,177.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1,007.7 мянган төгрөг төвлөрч, 960,728.1 мянган төгрөгийн гүйлгээг хийж 67,887.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 95.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо зөрүүтэй илүү шилжүүлснээс үүссэн байна.

Бараа материалын үлдэгдэл 8,382.03 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-аас олгосон 3,077.5 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг, БШУЯ-аас 9,928.4 мянган төгрөгийн цахим анги байлуулахад олгосон бараа материал голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1,237,183.6 мянган төгрөг болж өссөн нь цахим анги байгуулахад шаардлагатай 17,875.0 мянган төгрөгөөр эд хогшил, тоног төхөөрөмж нөхөн хангалт зардлаас худалдан авсан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,130,311.5 мянган төгрөгийн сургуулийн хичээлийн байр, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 88,997.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил үнэ төлбөргүй шилжүүлэн авсан гол нөлөө үзүүлсэн байна.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 1,240,125.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,084,764.0 мянган төгрөг болсон нь тайлант оны үр дүнгээр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,005,179.1 мянган төгрөгөөр төлөвлөж 2022.07.25-ны өдөр аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд 6 удаа өөрчлөлт орж БЕГ-ын даргын 2023 оны А/461 тоот тушаалаар улсын төсвөөс 1,026,346.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин, цалингийн шатлал нэмэгдсэнтэй холбоотой цалин хөлс түүнтэй адилтгах зардлыг 147,037.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 18,380.0 мянган төгрөгөөр тус тус дээд шатны байгууллагаас оны эхний төсвөөс нэмэгдүүлэн баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 915,914.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 848,026.5 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 67,887.9 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 91,262.7 мянган төгрөгийн санхүүжилт авч 90,932.2 мянган төгрөгийг зарцуулж 330.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	1,985.6	1,985.6	-	100.0
2	80312 Сургалт семинар	992.8	992.8	-	100.0
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,985.6	1,985.0	0.6	100.0
4	81801 Үдийн цай хөтөлбөр	47,766.7	42,106.3	5,660.4	88.1
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	81,413.9	76,870.5	4,543.4	94.4
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	20,892.8	20,613.0	279.8	98.7
7	81823 Боловсролын байгууллагын багш	4,467.7	4,467.6	0.1	100.0
8	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	4,829.9	2,550.5	2,279.4	52.8
9	81834 Боловсролын стандарт, сургалтын	627,865.6	586,763.4	41,102.2	93.5
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	144,195.9	130,228.1	13,967.8	90.3
11	81848 Сурах бичгийн түрээс	1,370.9	902.7	468.2	65.8
12	80112 Нийтлэг үйлчилгээ	91,262.7	90,932.2	330.5	99.6
	ДҮН	1,029,030.1	960,397.7	68,632.4	93.3

Эх сурвалж: Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн захирал Г.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургууль сургууль Номгон аудит ХХК-д 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэхээр санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2024.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн нийт зардлаар 667,124.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,671.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,003.4 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно. Тайлант онд цалин, шимтгэлийн зардлыг 55,068.0 мянган, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 192.3 мянган, үдийн цайны зардлыг 5,660.4 мянган, төлбөр хураамжийн зардлыг 468,9 мянган, бараа үйлчилгээний зардлыг 280.5 мянган төгрөгөөр хэмнэж, оны эцэст 67,887.9 мянган төгрөг зарцуулаагүй үлдэгдэл харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ нь тайлант оны эцэст дээд газраас нэмэлт санхүүжилт холбоотой хэмнэлт үүссэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 928,068.2 мянган төгрөгийн 85 гүйлгээ, зарлагын 101,327,4 мянган төгрөгийн 18 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 12 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, менежментийн захидлаар 399,8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт , 30,031.0 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	399.8	1	399.8	100
Албан шаардлага	3	30031.0	3	30031.0	100
Нийт дүн	4	30,430.80	4.00	30,430.80	100

Эх сурвалж: Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023.05.15-ны өдрийн 29 тоот албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.15-ны өдөр 29 тоот албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гаргаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

---oOo---





САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/106/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2023 оны 02 дугаар сарын 20-ний өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр: “Номгон Аудит” ХХК

Захирал: Г.Саранчимэг

Аудитор: О.Мандах

Утас: 89010203 Цахим хаяг:  
[audit.nomgon@gmail.com](mailto:audit.nomgon@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.